

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/160/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Х.Еркебулан Утас: 92921881 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт.....	18
Байхгүй .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3 Албан шаардлага .....	18
4.4 Зөвлөмж .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА Х.БАУЫРЖАН  
ТАНАА**

2022.02.17 № 76  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Мэргэжлийн хяналтын газар-Дүгнэлт

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Мэргэжлийн хяналтын газар-Дүгнэлт

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>158771269.20</u></b>	<b><u>174420223.87</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	158771269.20	174420223.87
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	250000.00	0.00
35130	Эм боох материал	250000.00	0.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	158521269.20	174420223.87
35410	Бичиг хэргийн материал	3183724.67	3144797.90
35420	Аж ахуйн материал	124872523.06	126494951.47
35470	Бусад хангамжийн материал	30465021.47	44780474.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>733988576.07</u></b>	<b><u>709120936.70</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	733988576.07	709120936.70
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	645380576.07	620512936.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	467822600.00	475394900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25583703.66	-37546579.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148616940.00	148616940.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-94216446.72	-105317396.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	736897330.25	741771170.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-622734583.64	-642747519.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37808341.29	44956324.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28898163.19	-26258763.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	25375100.00	25375100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-709278.33	-4733680.53
39217	Ном	1002440.07	1002440.07
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	88608000.00	88608000.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	88608000.00	88608000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>892759845.27</u></b>	<b><u>883541160.57</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>892759845.27</u></b>	<b><u>883541160.57</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	892759845.27	883541160.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	466489460.58	466489460.58
51101	Өмч: - төрийн	466489460.58	466489460.58
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	136387973.35	127169288.65
51210	Өмнөх үеийн үр дүн	-31184369.90	136387973.35
51220	Тайлант үеийн үр дүн	167572343.25	-9218684.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	289882411.34	289882411.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>892759845.27</u></b>	<b><u>883541160.57</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,355,419,464.36</b>	<b>1,149,831,339.50</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>166,658,502.36</b>	<b>28,619,439.50</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	166,658,502.36	28,619,439.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	166,658,502.36	28,619,439.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	166,658,502.36	28,619,439.50
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,188,760,962.00</b>	<b>1,121,211,900.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,137,204,500.00	1,102,196,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,137,204,500.00	1,102,196,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	51,556,462.00	19,015,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,156,462.00	18,137,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,400,000.00	878,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,187,847,121.11</b>	<b>1,159,050,024.20</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,187,847,121.11</b>	<b>1,159,050,024.20</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,126,027,099.28	1,137,662,340.52
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	758,061,090.00	759,143,460.00
210101	Үндсэн цалин	584,173,802.00	576,047,360.00
210102	Нэмэгдэл	135,252,785.00	159,743,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,707,400.00	23,353,000.00
210104	Урамшуулал	16,927,103.00	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,335,490.17	99,240,941.32
210201	Тэтгэврийн даатгал	61,683,624.12	68,877,455.02
210202	Тэтгэмжийн даатгал	8,236,899.22	7,610,874.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,778,641.11	6,088,700.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,444,658.11	1,522,175.33

Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	17,191,667.61	15,141,735.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	44,252,232.00	41,698,769.00
210301	Гэрэл, цахилгаан	5,068,900.00	3,358,157.00
210302	Түлш, халаалт	31,406,900.00	31,406,900.00
210303	Цэвэр, бохир ус	2,982,400.00	3,073,712.00
210304	Байрны түрээс	4,794,032.00	3,860,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	43,459,599.50	51,157,494.73
210401	Бичиг хэрэг	8,402,850.00	8,554,812.84
210402	Тээвэр, шатахуун	24,298,480.00	32,629,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,818,377.00	6,932,977.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	193,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,689,892.50	2,846,724.89
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	20,399,287.00	30,734,925.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,910,287.00	13,900,470.00
210502	Хоол, хүнс	2,489,000.00	2,627,973.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	14,206,482.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,844,957.53	46,938,891.17
210602	Тавилга	-	1,169,284.20
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,777,807.53	35,623,106.97
210604	Урсгал засвар	13,067,150.00	10,146,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	19,927,800.00	13,081,700.00
210702	Дотоод албан томилолт	19,927,800.00	13,081,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,167,936.88	24,576,119.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	17,601,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	473,000.00	589,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	717,000.00	717,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,000.00	248,614.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	877,000.00	1,877,000.00
210807	Газрын төлбөр	36,900.00	265,932.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,938,036.88	3,189,373.93

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	109,578,706.20	71,090,039.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	1,200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,878,706.20	69,890,039.37
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	61,820,021.83	21,387,683.68
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	38,949,000.00	4,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,549,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,400,000.00	4,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	22,871,021.83	17,387,683.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,871,021.83	17,387,683.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>167,572,343.25</b>	<b>(9,218,684.70)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>167,572,343.25</b>	<b>(9,218,684.70)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	466,489,460.58	289,882,411.34	-31,184,369.90	725,187,502.02
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	466,489,460.58	289,882,411.34	-31,184,369.90	725,187,502.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	466,489,460.58	289,882,411.34	<b>136,387,973.35</b>	892,759,845.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			-9,218,684.70	-9,218,684.70
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>466,489,460.58</b>	<b>289,882,411.34</b>	<b>127,169,288.65</b>	<b>883,541,160.57</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1216523511.00</b>	<b>1152375700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>27762549.00</b>	<b>31163800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	27762549.00	31163800.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	27762549.00	31163800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27762549.00	31163800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1188760962.00</b>	<b>1121211900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1137204500.00	1102196800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1137204500.00	1102196800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	51556462.00	19015100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27156462.00	18137100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24400000.00	878000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1171021911.00</b>	<b>1129925600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1171021911.00</b>	<b>1129925600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1081439340.17</b>	<b>1077374116.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	758061090.00	759143460.00
210101	Үндсэн цалин	584173802.00	576047360.00
210102	Нэмэгдэл	135252785.00	159743100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21707400.00	23353000.00
210104	Урамшуулал	16927103.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94335490.17	99240941.32
210201	Тэтгэврийн даатгал	61683624.12	68877455.02
210202	Тэтгэмжийн даатгал	8236899.22	7610874.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	5778641.11	6088700.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1444658.11	1522175.33
210205	Эрүүл мэндийн даатгал	17191667.61	15141735.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	44252232.00	41698769.00
210301	Гэрэл, цахилгаан	5068900.00	3358157.00
210302	Түлш, халаалт	31406900.00	31406900.00
210303	Цэвэр, бохир ус	2982400.00	3073712.00
210304	Байрны түрээс	4794032.00	3860000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	43597657.00	53853057.00
210401	Бичиг хэрэг	9577700.00	12041000.00
210402	Тээвэр, шатахуун	24268480.00	32629480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7614377.00	6932977.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250000.00	235800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1887100.00	2013800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31883011.00</b>	<b>22827943.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29633011.00	20199970.00
210502	Хоол, хүнс	2250000.00	2627973.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>82327300.00</b>	<b>62585900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	3830000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	63909250.00	41637100.00
210604	Урсгал засвар	18418050.00	17118800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>19927800.00</b>	<b>13081700.00</b>
210702	Дотоод албан томилолт	19927800.00	13081700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5354760.00</b>	<b>23742346.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1000000.00	17890900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	473000.00	629200.00
210803	Даатгалын үйлчилгээ	717000.00	717000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71000.00	248614.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55000.00	88000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	877000.00	1877000.00
210807	Газрын төлбөр	36900.00	265932.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2124860.00	2025700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1700000.00</b>	<b>1200000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1200000.00	1200000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>89582570.83</b>	<b>52551483.68</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>27762549.00</b>	<b>31163800.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	27762549.00	31163800.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>38949000.00</b>	<b>4000000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17549000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21400000.00	4000000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22871021.83</b>	<b>17387683.68</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22871021.83	17387683.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>45501600.00</b>	<b>22450100.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>45501600.00</b>	<b>22450100.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>45501600.00</b>	<b>22450100.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>45501600.00</b>	<b>22450100.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45501600.00	22450100.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-45501600.00</b>	<b>-22450100.00</b>

7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1102196800.00	1084809116.32
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1102196800.00	1084809116.32
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1098196800.00	1080809116.32
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	759883300.00	759143460.00
210101	Үндсэн цалин	576787200.00	576047360.00
210102	Нэмэгдэл	159743100.00	159743100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23353000.00	23353000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	102584300.00	99240941.32
210201	Тэтгэврийн даатгал	72188900.00	68877455.02
210202	Тэтгэмжийн даатгал	7598800.00	7610874.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	6079100.00	6088700.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1519800.00	1522175.33
210205	Эрүүл мэндийн даатгал	15197700.00	15141735.44
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	44196200.00	41698769.00
210301	Гэрэл, цахилгаан	5068900.00	3358157.00
210302	Түлш, халаалт	31406900.00	31406900.00
210303	Цэвэр, бохир ус	3081300.00	3073712.00
210304	Байрны түрээс	4639100.00	3860000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	53973100.00	50853057.00
210401	Бичиг хэрэг	12041000.00	12041000.00
210402	Тээвэр, шатахуун	31760600.00	29629480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7907700.00	6932977.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250000.00	235800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2013800.00	2013800.00
2105	<b>Нормативт зардал</b>	22450000.00	22449943.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20200000.00	20199970.00
210502	Хоол, хүнс	2250000.00	2249973.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	69400100.00	69398900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22280100.00	22280100.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	31000000.00	31000000.00
210604	Урсгал засвар	16120000.00	16118800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20397700.00</b>	<b>13081700.00</b>
210702	Дотоод албан томилолт	20397700.00	13081700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24112100.00</b>	<b>23742346.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17894500.00	17890900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	962000.00	629200.00
210803	Даатгалын үйлчилгээ	717000.00	717000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270000.00	248614.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99000.00	88000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1877000.00	1877000.00
210807	Газрын төлбөр	266900.00	265932.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2025700.00	2025700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1200000.00</b>	<b>1200000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1200000.00	1200000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4000000.00</b>	<b>4000000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4000000.00</b>	<b>4000000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4000000.00	4000000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1102196800.00</b>	<b>1084809116.32</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1102196800.00</b>	<b>1084809116.32</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1102196800.00	1084809116.32
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>63.00</b>	<b>62.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	44.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00
620004	Гэрээт ажилтан		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>63.0</b>	<b>62.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	46.00	45.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>19015100.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19015100.00</b>

<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	19015100.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3000000.00
Тээвэр, шатахуун	3000000.00
<b>Нормативт зардал</b>	378000.00
Хоол, хүнс	378000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15637100.00
Багаж, техник, хэрэгсэл	4000000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10637100.00
Урсгал засвар	1000000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	19015100.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19015100.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18137100.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	878000.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/36 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд төрийн захиргааны хяналт тавих замаар иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ авах, ажиллах хөдөлмөрлөх эрхийг хангах бизнес эрхлэгчийн таатай орчин бүрдүүлэх, төрийн өмчийн болон төсвийн байгууллагуудад санхүүгийн сахилгыг бэхжүүлэх, байгууллагад хуульч, ёс зүйтэй байдлыг хэвшүүлэх явдал зорилго, зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мэргэжлийн хяналтын газрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын комисс ажилладаг. Тус комисс нь байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, алба, салбар нэгжийн үйл ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгаж, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, анги, байгууллагын тодорхойлсон эрсдэлийг нэгтгэн, байгууллагын эрсдэлийн үнэлгээг тогтоож, тайланг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дотоод хяналт шалгалтын хэлтэст хүргүүлдэг байна.

Тус газарт 2021 онд дотоод аудитын шалгалт ирээгүй бусад эрх бүхий байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1187.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 17.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 13.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.2 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	158771.3	174420.2	15648.9
Үндсэн хөрөнгө	733988.6	709120.9	-24867.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>892,759.9</b>	<b>883,541.1</b>	<b>-9,218.8</b>
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	892,759.9	883,541.1	-9,218.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>892,759.9</b>	<b>883,541.1</b>	<b>-9,218.8</b>

Мөнгөн хөрөнгийн болон авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 174.4 сая төгрөг болж 15.6 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 127.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 13.6 сая төгрөгийн бараа материал хүлээн авч үйл ажиллагаандаа 125.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 709.1 сая төгрөг болж 24.8 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 30.0 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй 15.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 25.4 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 69.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 883.5 сая төгрөг болж 9.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 9.2 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1149.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 15.2 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого, нэмэлт санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 28.8 сая төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байр ашиглахтай холбоотой зардал, томилолт зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Цалингийн зардал, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлууд өмнөх оноос нэмэгдэж, томилолт зочны зардал, томилолт зочны зардал, урсгал шилжүүлэг зардлууд өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 1078.8 сая төгрөг, тодотгосон төсөв 1102.2 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 23.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, багаж, техник, хэрэгсэл, урсгал засварын зардлыг 45.3 сая төгрөгөөр нэмж, цалингийн зардлыг 3.2 сая, томилолтын зардлыг 17.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1.7 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Шалтгаан нь: Тус байгууллага нь тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага тул Ковид-19 цар тахлын улмаас хөдөө сумуудад хяналт шалгалт хийгдээгүйгээс хэмнэгдэх дотоод албан томилолтын зардлыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хилийн ариутгал, хяналт шалгалтад хэрэглэх нэг удаагийн амны хаалт, комбинзон зэрэг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл авахтай холбоотой зохицуулалт хийжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 1102.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1084.8 сая төгрөгийг зарцуулж, 17.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь үндсэн цалин, нийгмийн даатгалын шимтгэл, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, байрны түрээс, тээвэр шатахуун, шуудан холбоо, интернэтийн төлбөр, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, дотоод албан томилолт, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардлын хэмнэлт байна.

Нийт төсвийн 70.0 хувийг цалин, 9.1 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 3.8 хувийг тогтмол зардал, 4.7 хувийг хангамж бараа материалын зардал, 2.1 хувийг норматив зардал, 6.4 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 1.2 хувийг томилолт, зочны зардал, 2.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.4 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 0.9 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын тамгын газраас 18.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авчээ. Үүнээс хоолны зардалд 0.3 сая төгрөг, шатахууны зардалд 3.0 сая төгрөг, урсгал засварын зардалд 1.0 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 14.7 сая, нийт 19.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Мэргэжлийн хяналтын газар 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Мэргэжлийн хяналтын газар нь 2021 онд нийт 1084.8 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1084.8 сая төгрөгийн 119 мэдээллийг ил тод байршуулсан, 19 мэдээллийг хугацаа хоцроож нөхөж байршуулсныг шалгаж үзэхэд мэдээллээ засаж байршуулсантай холбоотой байна. 5.0 сая төгрөгөөс дээш мөнгөн дүнтэй нийтдээ 15 гүйлгээ буюу 116.2 сая төгрөгийн гүйлгээг бүрэн байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд аудитаар шилэн данстай холбоотой 16.3 сая төгрөгийн зөрчилд 1 заалттай зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг Мэргэжлийн хяналтын газрын 2021.09.27-ны 01/354 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 4. Аудитын илрүүлэлт

Байхгүй

#### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

#### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

#### 4.3 Албан шаардлага

Байхгүй

#### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мэргэжлийн хяналтын газар										
<b>Нийт дүн</b>											